

## ЗҮҮН АЗИ СУДЛАЛЫН ОЛОН УЛСЫН ХУРАЛ

П.ДЭЖИДМАА

“Ази судлал” гэдэг нь хэрэг дээрээ “Зүүн Ази судлал” юм гэж АНУ-ын Иллинойсын их сургуулийн Зүүн Ази, Номхон далайн судлалын төвийн захирал, профессор Жорж Т.Ю нэгэнтээ бичсэн байдаг. Зүүн Ази бол эртний түүхэн уламжлалтай бүс нутаг бөгөөд Зүүн Азийн соёл нь Хятадын соёлоос улбаалан аажмаар Солонгосын хойг, Япон, Вьетнам, Сингапур зэрэг Зүүн Азийн олон оронд тархсан билээ.

Ази тив ялангуяа Зүүн Ази дэлхийн бодлого, эдийн засаг, соёл шинжлэх ухаан техникийн хөгжилд жинтэй нөлөө бүхий бүс нутаг болоод байгааг Бээжин хотноо 2000 оны 9-р сарын 22-24-нд болсон “Зүүн Ази судлалын өнөөгийн байдал ба хэтийн төлөв” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал нотлон харуулав. Бээжин их сургуулийн Зүүн Ази судлалын төвөөс эрхлэн зохион байгуулсан уг хуралд АНУ, Япон, БНСУ, Монгол, ОХУ, Тайланд, Вьетнам, Сингапур, Канад, БНХАУ зэрэг 10 орны 40 шахам эрдэмтэд оролцож улс тус бүрийнхээ Зүүн Ази судлалын байдлыг илтгэв. Уг хуралд оролцсон ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, Монгол улсын Шинжлэх ухааны гавъяат ажилтан, академич, доктор, профессор Ч.Далай “Зүүн Ази ба Монгол Улс”, мөн хүрээлэнгийн ажилтан доктор (Ph) Л.Бэгзжав “Монгол улс дахь Зүүн Ази судлалын өнөөгийн байдал, хэтийн төлөв” гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Анх удаагаа болж буй олон улсын энэхүү томоохон хурлын ач холбогдлыг эрдэмтэд өндөр үнэлж, цаашид хоёр жил тутам хийж байх нь зүйтэй гэж санал нэгтэй үзээд хоёр дахь хурлыг дахин БНХАУ-д хийхээр тогтов.

Төв Азийн Монгол улс Зүүн хойт Ази, Зүүн Азийн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож байгаад талархаж байгаагаа ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн захирал, профессор Р.В.Рыбаков, Бээжин Их сургуулийн Зүүн Ази судлалын хүрээлэнгийн захирал, профессор Хао Бинь нар онцлон тэмдэглэж байлаа.

Японы эрдэмтэн Токиогийн Их сургуулийн Дорно дахины соёлын хүрээлэнгийн захирал, профессор Танака Акихико 2004 оны ээлжит хурлыг Монгол Улсад хийх санал гаргасныг хуралд оролцогчид, талархан дэмжсэн бөгөөд энэ саналыг манай тал анхаарч, зохих бэлтгэл хийх нь зүйтэй болов уу гэж санана.